



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 31

Есөнбулаг сум

“Хүүхдэд ээлтэй-Алтай” дэд хөтөлбөр  
батлах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “Ж” заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хүүхдэд ээлтэй– Алтай” дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Хүүхдэд ээлтэй–Алтай” дэд хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн эцэст аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ... оны  
... дүгээр сарын ...-ны өдрийн ... дүгээр  
тогтоолын ... дүгээр хавсралт



## ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ-АЛТАЙ ДЭД ХӨТӨЛБӨР

### НЭГ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Үндэслэл: “Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалал шаардлагатай байдаг.

Хүүхдийн эрхийг дээдэлсэн, хүүхдэд ээлтэй нийгмийг байгуулах нөхцөлийг хангахын төлөө төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн салбарынхан өөрсдийн үйл ажиллагаагаа хүүхдэд ээлтэй байдлаар тодорхойлж, бодлого үйл ажиллагаандаа тусган ажлаа уялдаа холбоотой зохион байгуулж хэрэгжүүлэх нь чухал байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020/ Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх үндэсний илтгэл, НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан дүгнэлт, зөвлөмж /2000, 2005, 2010, 2015 он/, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн тухай Конвенц, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль нь хүүхдийн эрх хамгаалал, эрүүл аюулгүй, хөгжих орчин, хүүхдэд ээлтэй төрийн үйлчилгээг бий болгож Хүүхдийн асуудлыг онцгойлон авч үзэж, тусгайлсан бодлого, зохицуулалтаар хангахыг шаардаж байна. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 тоот тогтоолоор Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг баталж, хүүхэд бүрийг хөгжил, хамгаалал, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах асуудалд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж байна.

НҮБ-ийн Хүүхдийн сан 2017-2021 онд Улс орныг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Говь-Алтай аймгийг сонгон, хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж, хүүхдэд ээлтэй орон нутгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ. Энэхүү хамтарсан хөтөлбөрийн үр дүнд:

Үр дүн 1: 2021 он гэхэд ядуу эмзэг бүлгийн хүүхдүүдийн эрүүл мэнд хоол тэжээл, ус ариун цэвэр ахуйн үйлчилгээний хүртээмж ашиглалт сайжирсан мөн хүүхдийн эсэн мэнд амьдрахуйд агаарын бохирдлын үзүүлэх нөлөөг бууруулах арга хэмжээний үр дүнг хүртсэн байна.

Үр дүн 2: 2021 он гэхэд хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүд тэгш хамруулсан, эрүүл чанартай сургалтын орчин дахь боловсролын үйлчилгээнд бүрэн хамрагдсан байна.

Үр дүн 3: 2021 он гэхэд хүүхдийн асуудлаарх үндэсний бодлого, төсөвлөлт, тогтолцоо түүний дотор хүүхэд хамгааллын тогтолцоог тэгш хамруулсан, тэгш боломжийг дэмжсэн тогтолцоо болгон хөгжүүлсэн байна.

### Хэрэгцээ шаардлага: \Өнөөгийн байдал\

Говь-Алтай аймгийн хэмжээнд 0-18 хүртэлх насны 22295 хүүхэд байгаагаас эрэгтэй 11420, эмэгтэй 10875 байна. Нийт хүн амын 36 хувийг хүүхэд эзэлж байна. Аймгийн хэмжээнд хагас өнчин 943, бүтэн өнчин 56, хөгжлийн бэрхшээлтэй 376 хүүхэд байна.

### Хүүхдийн эрүүл мэнд:

Манай аймагт 2013-2016 онд буюу сүүлийн 5 жилд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 86.1 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 66.1 хувийг нярайн эндэгдэл, нярайн эндэгдлийн 78.0 хувийг нярайн эрт үеийн эндэгдэл эзэлж байна.

2015-2016 он буюу сүүлийн хоёр жилийн байдлаар нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 16.2, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 20.4 байгаа нь улсын дундаж төвшнээс доогуур болж, мянганы хөгжлийн зорилтыг биелүүлсэн хэдий ч, хүүхдийн өвчлөл, эндэгдэл тогтвортой буурахгүй байна.

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 86.1 хувийг нялхсын эндэгдэл, нялхсын эндэгдлийн 66.1 хувийг нярайн эндэгдэл, нярайн эндэгдлийн 77.9 хувийг нярайн эрт үеийн эндэгдэл эзэлж байгаагийн гол шалтгаан нь эхийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалсан дутуу болон бага жинтэй нярай төрж байгаатай холбоотой байна.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 55.3 хувийг төрөх тойрны эмгэг, 17.5 хувийг осол гэмтэл, 13.5 хувийг төрөлхийн хөгжлийн гажиг, 10.8 хувийг амьсгалын тогтолцооны өвчнүүд эзэлж байна. Эдгээрээс осол гэмтэл, төрөлхийг гажиг улсын дунджаас 4 хувиар их байна. Осол гэмтлийн нас баралт 5-14 насанд хамгийн өндөр буюу 70 хувийг эзэлж байна. Түлэгдэлтийн 22 тохиолдол 2016 онд бүртгэгдсний 95.6 хувь нь тав хүртэлх насны хүүхэд байна. Иймээс хүүхдийн өсч торниж байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүүхдэд тавих анхаарал, халамжийг сайжруулах талаар эцэг, эх, асран хамгаалагчийн мэдлэг хангалтгүй, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн талаар хийгдсэн судалгаа байхгүй, эрүүл мэндийн боловсрол дутмаг, тэдэнд чиглэсэн тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. Охидын төрөлт 5 жилийн дунджаар 4 хувь байгаагийн 71.0 хувийг хөдөө сумын охид эзэлж байна.

Аймгийн нийт өрхийн ундны усны сайжруулсан эх үүсвэрийн хэрэглээ 48.3% байгаа нь улсын дундажтай харьцуулахад 29.6%-иар бага. Сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хэрэглээ 60.6% буюу улсын дунджаас 23%-аар бага байна.

### Хүүхдийн боловсрол:

Төрийн 27, хувийн өмчийн 1 нийт 28 сургуульд өдрийн ангийн 501 бүлэгт 11358, дүйцсэн хөтөлбөрөөр 382, нийт 11740 сурагч суралцаж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1160, аравдугаар ангид 630 суралцагч элсэн суралцаж байна. Аймгийн хэмжээнд бага боловсрол эзэмшүүлэх 4, суурь боловсрол эзэмшүүлэх 3, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх 20, цогцолбор сургууль 1 ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуульд 5301 малчны, 168

хөгжлийн бэрхшээлтэй, 44 бүтэн өнчин хүүхэд суралцаж байна. Өдрийн ангид бага боловсролын 244 бүлэгт 5568, суурь боловсролын 168 бүлэгт 3803, бүрэн дунд боловсролын 89 бүлэгт 1987 сурагч суралцаж байна. Дүйцсэн хөтөлбөрөөр 382 хүүхэд суралцаж байгаагаас сургууль завсардсан 15 хүүхэд шинээр элсэн суралцаж байна.

Сургуулиудын анги дүүргэлт их, ээлжийн коэффициент нь өндөр хичээлийн бус цагаар сургууль дээр хүүхэд гэр бүлд чиглэсэн хөгжил төлөвшлийн арга хэмжээ зохион байгуулах анги танхимын хүрэлцээ муу байна. Аймгийн хэмжээнд 142 дугуйлан секцэд 9109 хүүхэд хамрагдан суралцаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын 29 цэцэрлэгийн 148 бүлэгт 4572 хүүхэд хүмүүжиж байгаагаас 3580 нь цэцэрлэгийн ангид, 992 нь хувилбарт сургалтаар суралцаж байна. Энэ хичээлийн жилд 1080 хүүхэд шинээр элсэж, халамж эдэлдэг 27, хөгжлийн бэрхшээлтэй 33 хүүхэд хүмүүжиж байна. Сургуулийн өмнөх боловсролын бүлэг дүүргэлт 30,9 байна.

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 90,1%, бага боловсролын хамран сургалт 97%, суурь боловсролд хамрагдалт 92 хувьтай байна. Нийт 83 багийн 75-д нь гэр цэцэрлэг ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хангалт 99,9 %-тай, сургуулийн өмнөх боловсролын багшийн хангалт 99,2 хувьтай байна. Ерөнхий боловсролын сургуульд 703 багш, Сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгт 131 үндсэн багш ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуульд 1323 хүн ажиллаж байгаагийн 53,1 хувь буюу 703 үндсэн багш ажиллаж байна. Үндсэн багшийг боловсролоор нь авч үзвэл аймгийн хэмжээнд зөвлөх 1, тэргүүлэх 163, заах аргач багш 275 ажиллаж байгаа нь нийт багш нарын 62,4 хувь нь мэргэжлийн зэрэгтэй багш байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 513 хүн ажиллаж байгаагийн 131 нь үндсэн багш, 116 нь туслах багш байгаа нь нийт ажиллагсдын 48.1хувийг эзэлж байна.

Сургалтын цэвэр жин 2012-2013 оны хичээлийн жилд 95.3 хувь 2014-2015 оны хичээлийн жилд 95 хувь, 2015-2016 оны хичээлийн жилд 99.1 хувь, 2016-2017 оны хичээлийн жилд 95 хувь, 2017-2018 оны хичээлийн жилд 92 хувьтай буюу өмнөх оныхоос 3 хувийн бууралттай байна.

21 сургуулийн 2677 орны хүчин чадалтай стандартын 24, стандартын бус 6 дотуур байранд 1491 сурагч амьдрах хүсэлт гаргаж, бүрэн хамрагдлаа. Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн 1322 нь малчны хүүхэд байгаа нь байранд амьдарч буй сурагчдын 88,7 хувийг эзэлж байна. Зориулалтын бус 6 дотуур байртай сургууль байна. Аймгийн төвд сургууль дундын дотуур байртай бөгөөд түүнд 1, 2, 3 дугаар сургууль, Хантайшир-Эрдэм цогцолбор, Анагаах ухааны лицей сургуулийн нийт 140 хүүхэд амьдарч байна.

Нийт 29 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас 8 нь зориулалтын бус барилга байгууламжтай байна. Цэцэрлэг нь 2685 орны хүчин чадалтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Алтай сумын цэцэрлэгийн цэргийн ангийн салбар бүлэг, Тайшир, Цээл, Шарга, Эрдэнэ сумын цэцэрлэг, 7, 8 дугаар цэцэрлэг, Оюуны-Өргөө цэцэрлэг стандартын бус байранд үйл ажиллагаа явуулж байна.

### Хүүхэд хамгаалал:

2017 оны жилийн эцсийн байдлаар гэмт хэрэгт холбогдсон 14 хүүхэд, гэмт хэргийн хохирогч 16 хүүхэд, гэмт хэргийн улмаас нас барсан 6 хүүхэд /авто аваар-4/, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 3 хүүхэд, гэмт хэргийн улмаас бэртсэн хүүхэд 6, гэмт хэргийн гэрч 6 хүүхэд, ял шийтгүүлсэн 5 хүүхэд байна. Ял шийтгүүлсэн хүүхдүүдээс ял шийтгэгдээд сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан 1 хүүхэд, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхэд 3, хоригдож байгаа хүүхэд 1 байна. Зөрчил үйлдэж шийтгүүлсэн 4 хүүхэд байна.

Хурдан морь уралдаанч хүүхэд-933, хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар 108 утсанд хандан хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд-30, хүүхэд хамгааллын хамтарсан багаар үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо 28, гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн тоо 79, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо 7 байна.

Хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагаа орон нутагт тогтмолжоогүй үйл ажиллагаа нь эхлэл төдий байна. Хүүхдийн оролцоо, тэдний дуу хоолойг сонсох шийдвэртээ тусгах асуудал хангалтгүй байна.

Өнөөгийн байдлаар сумдад сургуулийн нийгмийн ажилтнаар дамжуулан хүүхэдтэй холбоотой тоо баримт судалгаа мэдээллийг авч байгаа нь сумын хэмжээний судалгаа мэдээлэл болж чадахгүй байна. Иймээс хүүхдийн аж байдлын талаарх тоон мэдээлэл судалгааг нарийвчлан гаргах цаг алдалгүй мэдээ мэдээллийг солилцох зорилгоор хүүхэд, гэр бүл залуучуудад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх албан хаагч сумдад ажиллах шаардлагатай байна. Мөн тухайн орон нутгийн удирдлагыг гэр бүл, хүүхэд, залуучуудын талаар бодит мэдээ, мэдээллээр хангах ажил хоцрогдож байгаагаас сумын Засаг даргаар ахлуулсан Хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан багууд төдийлөн үр дүнтэй ажиллахгүй, хүүхдэд чиглэсэн арга хэмжээ хангалтгүй байна.

Хүүхдийн оролцоог хангах, хүүхдийг сонсох, хүүхдэд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хүүхдэд чиглэсэн төсөв хөрөнгө оруулалтыг ч нэмэгдүүлэх шаардлага байна.

Орчин үеийн мэдээлэл технологийн хөгжлийг орон нутагт бүрэн бий болгож мэдээлэл солилцох, хүртэх боломжийг бүрдүүлэх, хүүхэд багачуудад эх орон, төрсөн нутгаараа бахархах үзлийг төлөвшүүлэн хичээлээс гадуурх соёл хүмүүжлийн ажлыг уламжлалт ёс заншлаасаа судлах ажилтай хослуулан явуулж байх шаардлагатай байна.

Ерөнхий боловсролын сургуульд бүх төрлийн хичээлийг мэргэжлийн багш нар зааж байгаа ч зөвхөн хичээлээр хязгаарлахгүйгээр хичээлээс гадуур хүүхдийн сонирхол, хэрэгцээнд тулгуурласан олон төрлийн хөгжлийн дугуйлан, сургалтууд хичээллүүлж хүүхдийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах асуудал учир дутагдалтай байна.

Багш, эцэг эхчүүд хүүхдийн асуудлаар нэгдэж ажиллахгүй байгаа болон залуу эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ ажиллах арга барил мэдлэг хангалтгүй байгаа

зэрэг нь хүүхдүүд сурах, хөгжих, төлөвших явцдаа буруу дадал хэвшилд сурахад нөлөөлж байна. Иймд хүүхэд өсч торниж байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүүхдэд тавих анхаарал, халамжийг сайжруулах талаар эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, хүүхдийн үндсэн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхийг хангах, хүүхдийн эрүүл, аюулгүй хөгжих орчин, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг зайлшгүй бий болгох чухал шаардлагууд зүй ёсоор тавигдаж байна.

Хүүхдийн оролцоог хангах, хүүхдийг сонсох, хүүхдэд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах орон нутгийн хэмжээний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, хүүхдэд чиглэсэн төсөв хөрөнгө оруулалтыг ч нэмэгдүүлэх шаардлага байна. Хүүхэд насанд нь оруулсан хөрөнгө оруулалт нь тэднийг насанд хүрээд нийгэмдээ оруулах хувь нэмрийг нь тодорхойлж байдаг.

Иймээс бид тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замаа тодорхойлон Засгийн газрын бодлого, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийн авьяас чадвар, хөгжил төлөвшлийн ээлтэй орчинг бүрдүүлэн “Эрдэм боловсролтой, эрүүл, хөгжиж төлөвшсөн ирээдүй хойч үеэ бэлтгэх” зорилгоор энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын тогтолцоог салбаруудын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлсэн, хүүхдийн эрхийг дээдэлсэн “Хүүхдэд ээлтэй” аймаг болно.

## ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Зорилт 1: Хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээг эрхэмлэж, хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангасан, эрүүл аюулгүй тав тухтай амьдрах орчинг бүрдүүлнэ.

Зорилт 2: Боловсролын салбарын үйлчилгээг хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй хүргэж, эцэг, эх, хүүхэд, багшийн хамтын ажиллагааг өрнүүлж, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй боловсролын орчинг бүрдүүлнэ.

Зорилт 3: Хүүхдэд ээлтэй хамгааллын үйлчилгээг бий болгож, хүүхдийн хамгаалуулах, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангасан орчинг бүрдүүлэн, нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлнэ.

Зорилт 4: Хүүхдэд ээлтэй засаглалыг бэхжүүлэн, хүүхдийн оролцоотойгоор орон нутгийн хүүхдэд чиглэсэн бодлого, шийдвэр, төсвийг нэмэгдүүлж, хяналт шинжилгээ үнэлгээний үр нөлөөг сайжруулна.

## ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 1: Хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээг бий болгож хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангасан, эрүүл аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

4.1.1 Эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр нялх бага насны хүүхдийн хоол тэжээлийн тусламж үйлчилгээг сайжруулна.

4.1.2 Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн асаргаа, сувилгааг сайжруулна.

4.1.2. Хүүхэд, өсвөр үеийнхэнд нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх зан үйл төлөвшүүлнэ.

4.1.3. Хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлс (агаар, ус, хөрсний бохирдол)-ийг бууруулахад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах

4.1.4 Зорилтот бүлгийн хүүхэд/хөгжлийн бэрхшээлтэй, бүтэн өнчин, өрх толгойлсон гэр бүлийн, амьжиргааны нэгдүгээр түвшний айл өрхийн/-д чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт 2: Боловсролын салбарын үйлчилгээг хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй хүргэж, эцэг, эх, хүүхэд, багшийн хамтын ажиллагааг өрнүүлэн, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй боловсролын орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

1. Багшийн хөгжлийг дэмжих зарчмаар сургалтын чанарыг ахиулж, хүүхэд бүрийг хөгжүүлж, төлөвшүүлнэ.
2. Боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг ханган хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхдийг боловсролд тэгш хамруулна.
3. Боловсролын салбарт хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин нөхцөл бүрдүүлж, аюулгүй байдал, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллана.
4. Сургууль цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.
5. Бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийн хөгжлийг дэмжинэ.

Зорилт 3: Хүүхдэд ээлтэй хамгааллын үйлчилгээг бий болгож хүүхдийн хамгаалуулах, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангасан орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд

1. Хүүхэд бүрийг тэгш хөгжүүлж, төлөвшүүлэх орчинг бүрдүүлнэ.
2. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудын төрөл хэлбэрийг нэмэгдүүлж, хүүхдийг оролцооны аргад суралцуулан идэвхжүүлж, үзэл бодлоо илэрхийлэх мэдээлэл олж авах шийдвэр гаргах түвшинд оролцох нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийг сонсох үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлнэ.
3. Хүүхдийг осол гэмтэл болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж хүүхдийн аюулгүй байдлыг ханган хүүхдийн эрхийг хамгаална.
4. Хүүхдүүдийг нийгмийн бүхий л орчинд үл хайхрах байдал дарамт мөлжлөгийн бүх хэлбэр эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж тэгш хөгжих боломжийг бий болгож хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ.
5. Хүүхдийн хөгжил төлөвшлийн анхдагч орчин гэр бүл эцэг эхийн хандлагыг өөрчилж хүүхдээ хөгжүүлж төлөвшүүлэхэд тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлнэ.

*Зорилт4:Хүүхдэд ээлтэй засаглалыг бэхжүүлэн, хүүхдийн оролцоотойгоор орон нутгийн хүүхдэд чиглэсэн бодлого, шийдвэр, төсвийг нэмэгдүүлж, хяналт шинжилгээ үнэлгээний үр нөлөөг сайжруулах зорилтын хүрээнд:*

1. Хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төлөвлөлт, төсөвлөлтийг хийж, төсвийн тодорхой хувийг хүүхдийн төлөө үйл ажиллагаанд хуваарилна.
2. Бизнес эрхэлж байгаа байгууллага нь хүүхдийн эрхийг хүндэтгэж бизнесийн бүхий л үйл ажиллагаа орчинд хүүхэд хамгаалал, аюулгүй байдлыг ханган хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамтын түншлэлийг хэрэгжүүлнэ.

#### ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1 Аймгийн Засаг дарга хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажилд зарцуулах хөрөнгийг улсын төсөв, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

5.2 НҮБ-ын хүүхдэд ээлтэй орон нутаг төслийн хүрээнд хөтөлбөрт тусгагдсан ажлыг зохион байгуулахад зарцуулах хөрөнгийг шийдвэрлэнэ.

5.3 Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар,Боловсрол соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийг сум, орон нутагт тухайн сумын Засаг дарга удирдлагаар хангаж ЗДТГ-ын дарга болон төсөл хөтөлбөр хариуцсан ажилтан, багийн Засаг дарга нар хамтран хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

#### ЗУРГАА. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангахад эцэг эх- багш-хүүхэд, гэр бүл-төрийн болон төрийн бус байгууллага-хүүхэд гэсэн гурван талт харилцаанд суурилан хэрэгжүүлнэ.

#### ДОЛОО. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

2017-2021 он

#### НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

- Улсын болон орон нутгийн төсөв
- НҮБ-ын Хүүхдийн сан
- Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан
- Гадаад, дотоодын байгууллагын тусламж, хандивын хөрөнгө

#### ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ

9.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэж, улмаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнана.

9.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт үнэлгээг хийнэ.



**АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ АЙМАГ  
БОЛОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН**

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

10.1.Хүүхэд бүр гэр бүлдээ эцэг эхийн хайр халамжид эрүүл энх өсч, хүмүүжиж төлөвших боломж бүрдэж, эцэг эх, асран хамгаалагч болон багш сурган хүмүүжүүлэгч, иргэдийн хүүхдэд тавих анхаарал, халамж, үүрэг хариуцлага нэмэгдэнэ.

10.2.Хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлсэн, хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн хүүхдэд ээлтэй орчин бүрдсэн байна.

10.3.Хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн болон хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.

10.4.Хүүхдийг сонсох, үзэл бодлыг нь хүндэтгэх хандлага төлөвшиж, сургууль, орон нутгийн түвшинд хүүхдийн оролцоо бодитой хэрэгжих боломж бүрдэнэ.

**ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ АЙМАГ БОЛОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН**

1. ЭРҮҮЛ МЭНД					
№	Шалгуур үзүүлэлт	2017	2018	2019	2020
1	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	19,7	18,8	16,0	15,0
2	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	16.4	15.8	14.8	14
3	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	9.3	8.9	8.7	8.5
4	Төрсний 1 цагийн дараа хөхийг амлуулсан хувь	97.4	97.8	98.0	98.4
5	6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллосон хүүхдийн эзлэх хувь	78.0	80.0	83.0	85.0
6	Туранхай хүүхдийн эзлэх хувь	1.3	1.2	1.1	1.0
7	Тураалтай хүүхдийн эзлэх хувь	0.5	0.4	0.2	0.1
8	Өсөлт хоцрогдолтой хүүхдийн эзлэх хувь	2.0	1.9	1.8	1.7
9	Зөвлөгөө өгөх ур чадварын сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтний тоо	240	360	120	120
10	Нөлөөлөл сурталчилгаанд хамрагдсан шийдвэр гаргагчдын хувь	0	30.0	45.0	50.0
11	6-23 сартай хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл, 5 хүртэлх насны хүүхдийг А амин дэмээр хангасан хувь	86.0	88.0	90.0	100
12	Сэргээн засах тусламж үйлчилгээ эзэмшсэн мэргэжилтний тоо	-	1	-	1
13	15-19 насны охидын төрөлтийн түвшин /15-19 насны 1000 охидод/	35.0	34.0	32.0	30.0
14	Осол гэмтлээс шалтгаалсан хүүхдийн эндэгдлийн тохиолдол	5	4	3	2

15	Уушгины хатгалгаа өвчний шалтгаант нас баралтын хувь (5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд)	12.0	11.5	11.0	10.0
16	Ерөнхий боловсролын сургуулиуд өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлсэн байна	0	20%	40%	50%

## 2. БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

№	Шалгуур	2017 он	2018 он	2019 он	2020 он
1	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг улсын дундаж түвшинд хүргэнэ. /2016-2017оны хичээлийн жилд 88.2%, 2017-2018 оны хичээлийн жилд 92%-тай байна.	88.2%	90%	91%	92%
2	Стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай цэцэрлэгийн тоо 13, холбогдоогүй цэцэрлэгийн тоо 16 холбогдох боломжтой цэцэрлэг тоо 5 байна. \ 2018 онд 5 цэцэрлэг, 2019 онд 6 цэцэрлэг, 2020 онд 5 цэцэрлэг\ 2020 онд цэцэрлэгийг 100 хувь стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болно.	44.8%	62%	82.7%	100%
3	Аймгийн 3 цэцэрлэг цэвэр усны гүний худагтай бөгөөд нэмж 12 цэцэрлэгийг гүний худагтай болгоно. \ 2018 онд 4 цэцэрлэг 2019 онд 4 цэцэрлэг, 2020 онд 3 цэцэрлэг \2020 онд нийт сургуулийн 78 хувийг аюулгүй ундны усаар хангана.	15.7%	36.8%	57.8%	78%
4	Аймгийн 29 цэцэрлэгийн 15 цэцэрлэг эргэн тойрондоо 2-3 метрт гадна гэрэлтүүлэгтэй. 14 цэцэрлэг гадна гэрэлтүүлэггүй байна. 14 цэцэрлэгийг гадна гэрэлтүүлэгтэй болгоно. \2018 онд 5 цэцэрлэг, 2019 онд 5 цэцэрлэг, 2020 онд 4 цэцэрлэг\ 2020 онд цэцэрлэгийн 100 хувь гадна гэрэлтүүлэгтэй болгоно. .	51.7%	68.9%	82.7%	100%
5	Бүрэн камертай 11 цэцэрлэг байдаг бөгөөд цаашид 14 цэцэрлэгийг бүрэн камержуулна. \2018 онд 5 цэцэрлэг, 2019 онд 5 цэцэрлэг, 2020 онд 4 цэцэрлэг 2020 онд цэцэрлэгийн 85 хувийг камержуулна.	37.9%	55.1%	68.9%	85%
6	Аймгийн 6 цэцэрлэг налуу замтай бөгөөд 10 цэцэрлэгийг боловсролд тэгш хамруулах орчныг бүрдүүлнэ. \2018 онд 4 цэцэрлэг, 2019 онд 3 цэцэрлэг, 2020 онд 3 цэцэрлэг\ 2020 онд 6 сургуулийг нэмэж налуу замтай болгоно.	20.6%	34.4%	44.8%	55%
7	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэхэд зориулж нийлүүлсэн ном, сургалтын материал, тоглоомын хөрөнгө	55,0%	70%	90%	100%
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамран сургалтын хувь	42%	50%	60%	60%
9	Цэцэрлэгээс гадуур хувилбарт сургалтуудад хамрагдалт/хувиар/	19,5%	20,0%	20,5%	21%

10	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ-д хамруулсан тоо	33	50	65	70
11	Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн болзлыг хангасан цэцэрлэгийн хувь	10%	30%	50%	
12	Аймгийн 5 сургууль цэвэр усны гүний худагтай бөгөөд нэмж 10 сургуулийг гүний худагтай болгоно.	17.2%	34.4%	51.7%	70%
13	Аймгийн 29 сургуулийн 8 сургуулийн эргэн тойронд 2-3 метрт гадна гэрэлтүүлэгтэй. 21 сургууль гадна гэрэлтүүлэггүй байна. 15 сургуулийг гадна гэрэлтүүлэгтэй болгоно.	27.5%	44.8%	62	80
14	Бүрэн камертай 1 сургууль байдаг бөгөөд цаашид 15 сургуулийг бүрэн камержуулна.	3%	20.6%	40%	55%
15	Дотуур байрны хатуу эдлэлийг сайжруулна. Аймгийн 22 дотуур байрны 1 байрны хатуу эдлэл сайн. 21 дотуур байрны хатуу эдлэлийг \ширээ, сандал, шкаф, номын тариур\ 100 хувь сайжруулна.	4	36.3	68.1	100%
16	Хүүхдэд ээлтэй сургуулийн болзлыг хангасан сургуулийн хувь	8%	30%	50%	70%
17	Хүүхдэд ээлтэй дотуур байрны болзлыг хангасан дотуур байрны хувь	5%	30%	50%	80%
18	Секц дугуйланд хамрагдсан хүүхдийн хувь	30%	50%	60%	70%
19	Стандартад нийцсэн багшийн хөгжлийн танхимуудын тоо	5	10	15	20
20	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй сургууль, цэцэрлэгийн хувь	100%	100%	100%	100%
21	Сургуулийн төсөвлөлт, төлөвлөлт, хяналт-шинжилгээтэй холбоотой үйл ажиллагаанд эцэг эх, иргэд, төрийн бус байгууллага иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулсан боловсролын байгууллагын тоо	0	6	12	20
22	Дотуур байр болон анги танхимд стандартад нийцсэн гар угаалтууртай сургуулийн тоо	9	4	4	17

### 3. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭХ ТҮВШИН


№	Үзүүлэлт	2017 оны суурь түвшин	2018 он	2019 он	2020 он
1	Сургууль, дотуур байран дахь хүүхэд хөгжлийн төвийн тоо	10	15	25	40
2	Төрөөс санхүүгийн дэмжлэг авсан хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын хувь	3%	5%	7%	9%
3	Хүүхдийн хэвлэлийн тоо	0	1%	1	1
4	Сургалт, нөлөөллийн ажилд хамрагдсан иргэдийн хувь	30%	40%	50%	60%
5	Угийн бичиг хөтөлдөг хүүхдийн тоо	-	10%	10%	20%
6	Миний гэр бүл хүүхэд хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо	0	1000	1000	1500
7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх сургалтын төвийн тоо	-	2	4	6
8	Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагыг	17	20	25	30

	өрөө танхимаар хангасан сургуулийн тоо				
9	Хүүхдээс гарсан санал санаачилга, төсөл, хүүхдийн авьяас чадвар, бүтээл, нийгэмд оруулсан хувь нэмрийг үнэлсэн тоо/хүүхдээр/	30	40	50	70
10	Дугуйлан сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн хувь	10%	20%	30%	50%
11	Өөрийн удирдлагын байгууллагад хамрагддаг хүүхдийн хувь	30%	40%	60%	70%
12	Хүүхдээс хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлтийн хувь	80%	85%	90%	100%
13	Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн тоо	0	1	3	6
14	Хүүхэд үйлдсэн гэмт хэргийн бууралтын хувь	6%	5%	5%	4%
15	Хүүхдэд зориулсан тоглоомын талбайн тоо	52	55%	55	60
16	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэд бүтцийг(барилга, зам талбайд) бий болгосон байгууллагын тоо	16	20	30	40
17	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч хүүхдүүдийн байцаалтад хууль ёсны төлөөлөгч оролцсон хувь	100%	100%	100%	100%
18	Шүүхээс ял шийтгүүлэн албадлагын арга хэмжээ авагдсан хүүхэдтэй сургалт хүмүүжлийн ажлын төлөвлөгөө гарган ажилласан хувь	30%	40%	50%	70%
19	Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхэдтэй ажилласан хувь	100%	100%	100%	100%
20	Эцэг эхийн зөвлөл ажилладаг байгууллагын тоо	10	30	50	100
21	Хамтарсан багаар үйлчилгээ үзүүлсэн кейсийн шийдвэрлэлтийн хувь	20%	50%	60%	70%
22	Хүүхэд хамгааллын үйлчилгээг хамтарсан багаар үзүүлдэг сумын хувь	5%	20%	50%	100%
23	Түр хамгаалах байртай болсон сумын тоо	0	1	2	3
24	Ерөнхий боловсролын сургуулиуд шийдвэр гаргахад өсвөр үеийнхнийг оролцуулах тогтолцоог бий болгосон байна.	10%	20%	40%	50%
25	Нийт өсвөр үеийнхэн албан ба албан бус сургалтын орчинд амьдрах ухаанд суурилсан хөтөлбөрт хамрагдсан байна.	0	20%	40%	50%
<b>4. Засаглалын чиглэлээр</b>					
1	Хүүхдэд ээлтэй Алтай хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь		30%	70%	90%
2	Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр гаргасан ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийн хувь	5%	8%	10%	30%
3	Аймаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Хүүхдийн төлөө зөвлөлийн болон, хүүхдийн төлөө хийсэн ажлыг хэлэлцэж хэвшсэн байдал	0	3	3	4
4	Хүүхдийн төлөө зөвлөлөө байгуулж, үйл ажиллагаа нь тогтмолжсон сумын тоо	3	10	15	20
5	Хүүхэд хамгааллын бодлоготой байгууллагын тоо	18	40	50	60

6	Хүүхдийн өрөөтэй байгууллагын тоо	2	10	30	50
7	Хүүхдийн төлөө нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх элчийг сонгон ажиллуулж байгаа сум, тосгоны тоо	8	15	18	20
8	Хүүхдээ сонсох өдөртэй болсон сум, тосгоны тоо	0	10	15	20
9	Хүүхдийн аж байдал, эрхийн хэрэгжилтийн талаар мэдээллийн санг жил бүр үүсгэсэн сум, тосгоны тоо	0	10	10	20
10	Орон нутгийн хөгжлийн сангаас хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан төсөв, хөрөнгө оруулалтын хувь	5%	8%	10%	15%
11	Сумын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтүүдийг хийхэд хүүхэд оролцуулж хэвшсэн сумын тоо	-	5	10	18
12	Хүүхдэд ээлтэй сумын тоо	0	5	10	15
13	Хувийн хэвшлийн эх үүсвэрүүдээс хүүхдэд үзүүлсэн тусламжийн дүн	-	-	-	-
14	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоо	70	100	150	300

-----oOo-----

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018  
 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 31  
 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт



ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ-АЛТАЙ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ  
 ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт 1. Хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээг бий болгож хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангасан, эрүүл аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:							
Үйл ажиллагааны чиглэл 1.1 Эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр							
№	Хөтөлбөрийн зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсвийн эх үүсвэр
1.1.1	Нялх бага насны хүүхдийн хоол тэжээлийн тусламж үйлчилгээг сайжруулна.	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулна.	90%-аас доошгүй, сургалтын өмнөх болон дараах мэдлэгийн өсөлт	2018-2021	ЭМГ	Нэгдсэн эмнэлэг СӨЭМТ	Төсөл хөтөлбөр
		Дэмжлэгт хяналтыг зохион байгуулна.	Жил бүр 100% хамруулна.	2018-2021	ЭМГ	НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр
		Зөвлөгөө авсан эцэг эх, асран хамгаалагчийн тоог сар бүрийн мэдээнд авдаг болно.	22 нэгжүүд 100% мэдээлдэг болсон байна.	2018-2021	ЭМГ	СӨЭМТ	Улсын төсөв
		Нялх бага насны хүүхдийн хооллолтын талаар эцэг эх, асран хамгаалагчийн мэдлэг, дадлыг үнэлэх судалгаа авна.	5 хүртэл насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдын 15%-аас доошгүйг хамруулна	2018-2021	ЭМГ	СӨЭМТ	Улсын төсөв
		5 хүртэл насны хүүхдийн өсөлт хөгжилтийн хэмжилтэд үнэлгээ хийнэ.	Жил бүр	2018-2021	ЭМГ	СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Тураал, туранхай, өсөлт хоцрогдолтой хүүхдийг эмчилгээнд хамруулна.	5 хүртэл насны хүүхдийн 30%-аас доошгүйг хамруулна	2018-2021	ЭМГ	НЭ, СӨЭМТ	Улсын төсөв
		Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд жил бүр тураал, туранхай, өсөлт хоцрогдолтой хүүхдийн зуны сувилал ажиллуулна.	Эмчлэх шаардлагатай хүүхдийг 100% хамруулна.	2018-2021	ЭМГ	СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв

		Зорилтот бүлгийн хүүхдэд хоол хүнсний дэмжлэг үзүүлнэ.	Үзүүлсэн хүүхдийн тоо	2018-2021	ХХҮГ	ЭМГ, ГБХЗХГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
1.1.2	Олон нийтэд түшиглэсэн нялх бага насны хүүхдийн асаргаа, сувилгааг сайжруулна	Бага насны хүүхдийн асаргаа сувилгааны зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах /ОНХӨЦМ/	СӨЭМТ-ийн эмч эмнэлгийн мэргэжилтнийг 100% хамруулна, мэдлэгийн өсөлт үнэлнэ.	2018-2021	ЭМГ	НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр
		Дэмжлэгт хяналтыг зохион байгуулна.	Жил бүр 22 нэгж байгууллагын 100% хамруулна.	2018-2021	ЭМГ	НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр
		Бага насны хүүхдийн асаргаа сувилгааны талаар эцэг эх, асран хамгаалагч/өвөө эмээ, дүүгээ асарч буй хүүхдүүдэд/-ийн мэдлэг, дадлыг үнэлэх судалгаа авна.	5 хүртэл насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдын 15-аас доошгүй хувийг хамруулсан байна	2018-2021	ЭМГ	СӨЭМТ	Төсөл хөтөлбөр
1.1.3	Эмч эмнэлгийн мэргэжилтэн, эцэг эх, асран хамгаалагчдад дархлаажуулалтын ач холбогдол, вакцинд эргэлзэх байдлыг арилгах сургалт сурталчилгаа хийнэ.	Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулна.	Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах	2018-2021	ЭМГ	НЭ,СӨЭМТ	Төсөл хөтөлбөр
		Эцэг эх, асран хамгаалагчдад сурталчилгаа хийнэ.	Эцэг эх, асран хамгаалагчдад сурталчилгаа хийх	2018-2021	ЭМГ	НЭ,СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
<b>Үйл ажиллагааны чиглэл 1.2 Өсвөр үеийн эрүүл мэндийн чиглэлээр</b>							
1.2.1	Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна.	Өсвөр насны хүүхдүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлын судалгаа авна.	Судалгаатай болсон байна.	2018-2021	ЭМГ	ГБХЗХГ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр
		Өсвөр насны сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгнө.	Сэтгэл зүйн зөвлөгөө авах хүүхдийн тоо	2018-2021	ЭМГ	ГБХЗХГ	Улсын төсөв
		Өсвөр насныханд сэтгэцийн эрүүл мэндийн сургалтууд зохион байгуулна.	Сургалтанд хамрагдсан өсвөр үеийнхний эзлэх хувь	2018-2021	ЭМГ	ГБХЗХГ, НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Сэтгэцийн эрүүл мэндийн сургагч багш нараар сэтгэцийн эрүүл мэндийн сургалт зохион байгуулна.	Сургалтад зорилтот бүлгийн 90-ээс доошгүй хувийг хамруулна	2018-2021	ЭМГ	ГБХЗХГ, БСУГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв

		Эцэг, эх, асран хамгаалагчдад хүүхдийн эрүүл мэндийн болон сэтгэцийн эрүүл мэндийн сургалт зохион байгуулна.	Сургалтад зорилтот бүлгийн 70-аас доошгүй хувийг хамруулна	2018-2021	ЭМГ	ГБХЗХГ, БСУГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Боловсролын нийгмийн ажилтан, сургуулийн эмч, сумын эмч нарыг сэтгэл заслын анхан шатны зөвлөгөө үйлчилгээ өгөхөд чадавхжуулна.	Сургалтад зорилтот бүлгийн 70-аас доошгүй хувийг хамруулна	2018-2021	ЭМГ	ГБХЗХГ, БСУГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
1.2.2	Өсвөр үеийнхнийг БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлнэ.	“Өсвөр үе – Ирээдүйн босго” төвийн үйл ажиллагаанд үнэлгээ хийнэ.	Жил тутам үнэлгээ хийнэ. Стандартын хэрэгжилтийн хувь	2018-2021	ЭМГ	ГБХЗХГ, НЭ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Хүүхэд, өсвөр үеийнхэнд хүчирхийллээс сэргийлэх хүрэхүйн хөтөлбөрөөр сургалт зохион байгуулна.	Сургалтад 30-аас доошгүй хувийг хамруулсан байна	2018-2021	ЭМГ	БСУГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Өсвөр үеийнхэнд бэлгийн замаар дамжих халдвар, нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт зохион байгуулна.	Сургалтад 30-аас доошгүй хувийг хамруулсан байна	2018-2021	ЭМГ	НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Өсвөр үеийнхэнд бэлгийн замаар дамжих халдвар, нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалтыг эцэг, эх, асран хамгаалагчдад зохион байгуулна.	30%-аас доошгүй	2018-2021	ЭМГ	НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэхийг сурталчилсан уралдаан тэмцээн зохион байгуулна.	Зохион байгуулсан ажлын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ЭМГ	НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Үе тэнгийн сургагч нарыг чадавхжуулна.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ЭМГ	БСУГ ГБХЗХГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Охид, хөвгүүд, эрүүл мэндийн клубуудыг чадавхжуулах, нөлөөллийн арга зүйд сургана.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ГБХЗХГ	ЭМГ, ГБХЗХГ БСУГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
<b>Үйл ажиллагааны чиглэл 1.3</b> Зорилтот бүлгийн хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.							



1.3.1	Зорилтот бүлгийн хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүрдмэл үзлэгийг 18 сум, 2 тосгоныг хамруулан хийх, хөгжлийг бэршээлийг тогтоох судалгааг хийнэ.	Судалгаатай болсон байна	2018-2021	НБХ	ХХҮГ, ЭМГ, ГБХЗХГ, БСУГ НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, сувилгааны талаар эцэг, эх, асран хамгаалагчдад сургалт сурталчилгаа хийнэ.	Зохион байгуулсан сургатын тоо, хамрагдсан хүний тоо	2018-2021	ЭМГ	ХХҮГ, БСУГ ГБХЗХГ, НЭ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		УАУТ-ийг түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах тусламж үзүүлнэ.	Эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ЭМГ	УАУТ	Улсын төсөв
<b>Үйл ажиллагааны чиглэл 1.4</b> Ундны усны эрүүл аюулгүй байдлыг хангана.							
1.41	Ундны усны хүртээмжийг сайжруулж, эрүүл аюулгүй байдлыг хангана.	Сум бүр усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулж батлуулна.	18 сум төлөвлөгөө батлуулна, хэрэгжилтийн хувь	2018-2021	АЗДТГ	ЭМГ, сумдын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хөдөөний 19 сумын усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд үнэлгээ хийнэ.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2018-2021	АЗДТГ ЭМГ	сумдын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Өрхийн түвшинд усны аюулгүй байдлыг хангах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулна.	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамрагдсан хүний тоо	2018-2021	ЭМГ	СӨЭМТ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Ухаалаг худгийн сервертэй болно.	5-аас	2018-2021	АЗДТГ ЭМГ	Ундарга-Алтай ОНӨҮГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Сургууль цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан АЦБ-аар хангана.	100%	2018-2021	АЗДТГ	БСУГ сумдын ЗДТГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Сургууль цэцэрлэгийг хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан саваар хангана.	100%	2018-2021	БСУГ	Сургууль, цэцэрлэг	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Айл өрхийг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны савтай болгоно.	Айл өрхийн 50%	2018-2021	сумдын ЗДТГ	ЭМГ	Хувь хүн, Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Ундны усны эхийг хамгаална.	3-аас доошгүй	2018-2021	сумдын ЗДТГ	БОАЖГ ЭМГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв

		Сургууль цэцэрлэгийг худагжуулна.	12	2018-2021	БСУГ	сумдын ЗДТГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Аймгийн төвийн агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг авна.	Ажлын тоогоор	2018-2021	АЗДТГ	БОАЖГ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
<b>Үйл ажиллагааны чиглэл 1.5</b> Иргэдийн оролцоотойгоор ЭМБ, айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулна.							
1.5.1	Ариун цэврийн байгууламжийн стандартын хэрэгжилтийг нэмэгдүүлнэ.	ЭМБ-ын ариун цэврийн байгууламжийг сайжруулах уралдаан зарлаж дүгнэнэ.	4	2018-2021	ЭМГ	СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Иргэдэд орчны бохирдол, эрүүл ахуйн сургалт, сурталчилгаа зохион байгуулна.	8	2018-2021	ЭМГ	СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
		Айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах аян зохион байгуулна.	4	2018-2021	ЭМГ	Сумдын ЗДТГ, СӨЭМТ	Төсөл хөтөлбөр Улсын төсөв
<b>Зорилт 2</b>							
<b>Боловсролын салбарын үйлчилгээг хүүхэд бүрт тэгш хүртээмжтэй хүргэж, эцэг, эх, хүүхэд, багшийн хамтын ажиллагааг өрнүүлж, хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй боловсролын орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд:</b>							
№	Хөтөлбөрийн зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсвийн эх үүсвэр
2.1	Багшийн хөгжлийг дэмжих зарчмаар сургалтын чанарыг ахиулж, хүүхэд бүрийг хөгжүүлж, төлөвшүүлнэ.	Багш хөгжлийн танхимуудыг байгуулна.	80%	2018-2021	БСУГ	БСУГ ГБХЗХГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Багш нарыг чадваржуулах хөгжлийн сургалтуудад хамруулна.	Жил бүр	2018-2021	БСУГ	Сургууль, цэцэрлэг	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийн хөгжлийг дэмжинэ.	СӨБ-ын байгууллагын удирдлагууд багш, ажилтнуудад чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулна.	100%	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Төсөл хөтөлбөр
		Бага насны хүүхдийн хөгжлийн стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ.	29 цэцэрлэгт	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Бага насны хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн тоог нэмэгдүүлнэ.	2 удаа	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр

2.2		Гэр цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хувилбарт сургалтыг зохион байгуулна.	29 сумд	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлнэ.	10-аас доошгүй төв	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		СӨБ-ын байгууллагын барилгын их засварыг хийнэ.	5 цэцэрлэг	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
2.3	Боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг ханган хамран сургалтыг нэмэгдүүлж, хүүхдийг боловсролд тэгш хамруулна.	ЕБС нь хүүхэд бүрийн ялгаатай байдлыг харгалзан, тэдний сэтгэл хангалуун, тэгш хамран суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.	Орчин сайжирсан байна.	2018-2021	БСУГ, ЕБС, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Баррель үсэг, дохионы хэлний багшийг бэлтгэнэ.	25-аас доошгүй	2018-2021	БСУГ, ЕБС, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр
		Дотуур байрны орчин нөхцөлийг гэрийн нөхцөлд ойртуулна.	20 дотуур байр	2018-2021	БСУГ, ЕБС,	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв, ОНХС, Төсөл хөтөлбөр
		Алслагдсан сумдын малчдын хүүхдэд боловсролын үйлчилгээг хүргэх, тэгш хамруулах чиглэлээр модуль сургалтыг зохион байгуулна.	3-аас доошгүй модуль боловсруулна.	2018-2021	БСУГ,	Сумдын ЗДТГ, ЕБС, цэцэрлэгүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургууль, боловсролд бүрэн хамруулна.	100%	2018-2021	БСУГ	Сургууль	-
		Сургууль цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдах дэд бүтцийг бүрдүүлнэ.	100%	2018-2021	БСУГ, ЕБС, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр
2.4	Боловсролын салбарт хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй орчин нөхцөл бүрдүүлж, аюулгүй байдал, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллана.	Гамшгийн бэлэн байдлыг хангах менежментийг сайжруулах чиглэлээр чадавжуулах сургалтыг зохион байгуулна.	3 удаа	2018-2021	БСУГ, ЕБС, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ, ОНБГ	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр
		Халиун, 2-р сургуулийн туршлагыг бусад сургуулиудад түгээн дэлгэрүүлнэ.	56 байгууллагад	2018-2021	БСУГ, ЕБС, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ, ОНБГ	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр
		Гамшгийн бэлэн байдлыг хангах чиглэлээр сурагчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, манлайллыг нэмэгдүүлнэ.	Ажлын тоогоор	2018-2021	БСУГ, ЕБС, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ, ОНБГ	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр

		Сургууль цэцэрлэгийн барилгыг паспортжуулж, эрсдлийн үнэлгээг тогтооно.	58 байгууллагад	2018-2021	БСУГ, ЕБС, цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ,	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр
		Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнс, Үдийн цай хөтөлбөрийн хоол хүнсний аюулгүй байдал, хадгалалт хамгаалалт, чанар стандартыг тогтмол хангана.	Үр дүнгээр	2018-2021	БСУГ, ЕБС, цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ,	-
		Сургууль цэцэрлэг дээрээ хүүхдүүд ундны цэвэр усаар хангагдах боломжийг бүрдүүлнэ.	20-оос доошгүй сургууль цэцэрлэгт	2018-2021	БСУГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ,	Улсын төсөв, ОНТ, Төсөл хөтөлбөр
		Сургууль цэцэрлэгүүдийг гар угаалтуурын стандартыг хангуулна.	17	2018-2021	БСУГ	АЗДТГ, Сумдын ЗДТГ,	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр
2.5	Сургууль цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд эцэг, эх, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.	Сайн сургуулийг дэмжих аргачлалаар сургууль, цэцэрлэгийн өөрийн үнэлгээг хийнэ.	58 байгууллагад	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	, Төсөл хөтөлбөр
		Сургууль, цэцэрлэгийн зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, эцэг эхийн зөвлөлийг идэвхжүүлнэ.	58 байгууллагад	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	-
		Төсвийн төлөвлөлтөд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	58 байгууллагад	2018-2021	БСУГ,	Сургууль, цэцэрлэг	-
		Сургууль, цэцэрлэгүүдэд эцэг эх, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор төлөвлөлт, төсвийн мониторинг хийнэ.	15-аас доошгүй сургуульд	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	-
		Сургууль, цэцэрлэгийн байгууллагуудын дүрэм, журамын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулна.	58 байгууллагад	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	-
		Эцэг эх, олон нийтийг хамарсан бүтээлч ажлуудыг зохион байгуулна.	Ажлын тоогоор	2018-2021	БСУГ, Цэцэрлэгүүд	Сумдын ЗДТГ цэцэрлэгүүд	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр

**Зорилт 3: Хүүхдэд ээлтэй хамгааллын үйлчилгээг бий болгож хүүхдийн хамгаалуулах, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангасан орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд**

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсвийн эх үүсвэр
3.1	Хүүхэд бүрийг тэгш хөгжүүлж, төлөвшүүлэх орчинг бүрдүүлнэ.	Хүүхэд багачуудын авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх "Мазаалай" хүүхдийн театрыг байгуулж хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөөмжөөр хангаж дугуйлан, сургалт явуулах орчинг бүрдүүлнэ.	Дугуйлан сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2019	ГБХЗХГ	АЗДТГ	Улсын төсөв Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн "Андууд" зуслангийн үйл ажиллагааг сайжруулж, хүүхэд хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээ, төрөл хэлбэрийг өргөжүүлж биеийн тамирын заал, спортын тоглоомын хэрэгслийн тоог нэмэгдүүлнэ.	Нэмэгдсэн дүнгээр	2018-2021	БТСГ, БСУГ, Сумын ЗДТГ	АЗДТГ	Улсын төсөв ОНХС ОНТ Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцсэн хөгжлийн сургалт дугуйлан, амьдрах ухааны сургалтуудыг зохион байгуулна.	сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ БСУГ ТББ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн дунд зохион байгуулагдах уралдаан, наадам, тэмцээний төрөл хэлбэрийг нэмэгдүүлэн аймаг, баруун бүс, улсын хэмжээнд зохион байгуулан, хүүхэд бусдаасаа суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.	10-аас доошгүй	2018-2021	ГБХЗХГ БТСГ	АЗДТГ Сумын ЗДТГ БСУГ БТСГ, Алтай чуулга	Улсын төсөв ОНХС Төсөл хөтөлбөр
		Хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, суралцахад чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн музей, номын сан, хэвлэл мэдээлэл, соёл, урлагийн байгууллага, хүмүүсийн оролцоотой зохион байгуулна.	сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах	сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ГБХЗХГ	ЕБС	Улсын төсөв Төсөл хөтөлбөр

№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсвийн эх үүсвэр
3.1	Хүүхэд бүрийг тэгш хөгжүүлж, төлөвшүүлэх орчинг бүрдүүлнэ.	Хүүхэд багачуудын авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх “Мазаалай” хүүхдийн театрыг байгуулж хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөөмжөөр хангаж дугуйлан, сургалт явуулах орчинг бүрдүүлнэ.	Дугуйлан сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2019	ГБХЗХГ	АЗДТГ	Улсын төсөв Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн “Андууд” зуслангийн үйл ажиллагааг сайжруулж, хүүхэд хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхэд залуучуудын бие бялдрыг хөгжүүлэх, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээ, төрөл хэлбэрийг өргөжүүлж биеийн тамирын заал, спортын тоглоомын хэрэгслийн тоог нэмэгдүүлнэ.	Нэмэгдсэн дүнгээр	2018-2021	БТСГ, БСУГ, Сумын ЗДТГ	АЗДТГ	Улсын төсөв ОНХС ОНТ Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн хэрэгцээ сонирхолд нийцсэн хөгжлийн сургалт дугуйлан, амьдрах ухааны сургалтуудыг зохион байгуулна.	сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ БСУГ ТББ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн дунд зохион байгуулагдах уралдаан, наадам, тэмцээний төрөл хэлбэрийг нэмэгдүүлэн аймаг, баруун бүс, улсын хэмжээнд зохион байгуулан, хүүхэд бусдаасаа суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.	10-аас доошгүй	2018-2021	ГБХЗХГ БТСГ	АЗДТГ Сумын ЗДТГ БСУГ БТСГ, Алтай чуулга	Улсын төсөв ОНХС Төсөл хөтөлбөр
		Хүүхдэд байгаль орчноо хайрлах, үндэсний өв уламжлал, соёл, ёс заншлаа мэдэх, хүндэтгэх, суралцахад чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн музей, номын сан, хэвлэл мэдээлэл, соёл, урлагийн байгууллага, хүмүүсийн оролцоотой зохион байгуулна.	сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах	сургалтын тоо, хамрагдсан хүүхдийн тоо	2018-2021	ГБХЗХГ	ЕБС	Улсын төсөв Төсөл хөтөлбөр

		чадвартай болгон төлөвшүүлэн хөгжүүлэх цогц сургалтыг зохион байгуулна.					
		Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай, чөлөөт цагийн төв байгуулах, тохижуулах, засварлах ажлыг үе шаттай зохион байгуулна.	20-оос доошгүй	2018-2021	Сумын ЗДТГ	АЗДТГ	Улсын төсөв ОНТ Төсөл хөтөлбөр
3.2	Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагуудын төрөл хэлбэрийг нэмэгдүүлж, хүүхдийн оролцооны аргад суралцуулан идэвхжүүлж үзэл бодлоо илэрхийлэх мэдээлэл олж авах шийдвэр гаргах түвшинд оролцох тогтолцоог хөгжүүлж хүүхдийг сонсох үзэл бодлыг нь хүндэтгэх нийгмийн хандлагыг төлөвшүүлнэ.	Хүүхдийн чуулганыг тогтмол зохион байгуулж хүүхдүүдийн санал бодлыг сонсон бодлого хөтөлбөртөө тусган ажиллана.	2 жил тутам	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн оролцооны байгууллагуудын төрөл хэлбэрүүдийг нэмэгдүүлэн, үйл ажиллагааг нь дэмжиж, сурталчилж, урамшуулж манлайллыг нэмэгдүүлнэ.	70%	2018-2021	ГБХЗХГ	БСУГ, ЕБС	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн оролцооны байгууллагуудын чадавхыг бэхжүүлнэ.	3 удаа	2018-2021	ГБХЗХГ	БСУГ, ЕБС	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн оролцооны шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлж сурталчилна.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ ЕБС	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдээс гарсан санал санаачилга, төсөл, хүүхдийн авьяас чадвар, бүтээл, нийгэмд оруулсан хувь нэмрийг үнэлж, дүгнэнэ.	Ажлын тоогоор	2018-2021	ГБХЗХГ	АЗДТГ ЕБС	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
3.3	Хүүхдийг осол гэмтэл болзошгүй эрсдэл, гэмт хэрэг зөрчилд ертөхөөс урьдчилан сэргийлж хүүхдийн	Гэмт хэрэгт холбогдсон болон ял эдэлж байгаа хүүхдийн эрхийг хамгаална	100%	2018-2021	ГБХЗХГ	Цагдаагийн газар	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн үйлдсэн болон тэдний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулж, гэмт хэргийн гаралт, холбогдогчийн тоог бууруулах арга хэмжээ авна.	4%	2018-2021	ГБХЗХГ	Цагдаагийн газар	Улсын төсөв Төсөл хөтөлбөр

аюулгүй байдлыг ханган хүүхдийн эрхийг хамгаална.	Цахим орчны зөв зохистой хэрэглээ цахим орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	6 удаа	2018-2021	ГБХЗХГ	Цагдаагийн газар БСУГ Телевизүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Хүүхэд, гэр бүлд зориулсан мэдээ мэдээллийн цахим хуудсыг нээж тэдэнд зөвлөн туслана.	2төрлөөр	2018-2021	ГБХЗХГ	БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Сургууль, цэцэрлэг бүрийн орчинд замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулж, хурд сааруулагчийг хийж, хүүхдийг зам тээврийн осол гэмтэлд өртөхөөс сэргийлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018-2021	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ ЦГ Сургууль цэцэрлэг	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Гэр хорооллын гудамжийг гэрэлтүүлэгжүүлэх, золбин нохойг устгах, явган хүний замыг сайжруулах, хог хаягдлыг багасгах, архи тамхи худалдаалдаг дэлгүүр цэгийг цөөлөх ажлыг зохион байгуулалттай хийж хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018-2021	Аймгийн ЗДТГ	Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Онцгой болон эрсдэлт байгаа хүүхдэд хүргэх тусламж үйлчилгээг хамтарсан багаар түргэн шуурхай, чанартай хүргэж кейс үйлчилгээнд ахиц гаргана.	100%	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Хурдан морь унаач хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажиллахад талуудын оролцоог нэмэгдүүлэн хүүхдийг эрсдэлээс хамгаална.	100%	2018-2021	ГБХЗХГ, ХХУГ, МХГ	Сумын ЗДТГ, баяр наадмын комисс	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Хурдан морь унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг ханган 100% хамгаалалтын хувцас хэрэгсэлтэйгээр уралдааны замд гаргаж хэвшүүлнэ.	100%	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ, баяр наадмын комисс	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Хүүхдийг ахуйн болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ Цагдаагийн газар	Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр



		Хүйтний улиралд гэр хорооллын хүүхдүүдийг тээвэрлэх, зуны улиралд зусланд амрах хүүхдүүдийг тээвэрлэх зориулалт бүхий хүүхдийн автобустай болно.	1	2019	ГБХЗХГ	АЗДТГ	Улсын төсөв Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр
		Гамшгийн үед хүүхдийн эрхийг хамгаалах, тэдэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх, сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагад гамшгаас хамгаалах дадлага, сургуулилалтыг тогтмолжуулна.	2 жил тутам	2018-2021	ГБХЗХГ	БСУГ, ЕБС	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Бага насны хүүхдийг осол гэмтлээс хамгаалах зорилгоор "Суурьтай халуун тогоо" аянг өрнүүлж зорилтод өрхийн айлуудыг халуун тогооны сууриар хангана	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2019	ГБХЗХГ	Сумын ЗДТГ, СӨЭМТ, цэцэрлэгүүд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
3.4	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийг нийгмийн бүхий л орчинд үл хайхрах байдал дарамт мөлжлөгийн бүх хэлбэр эрсдэлт өртөхөөс урьдчилан сэргийлж тэгш хөгжих боломжийг бий болгож хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сэргээн засах, нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд анхааран хөгжүүлэх сургалтын төвүүдийг байгуулж ажиллуулна.	6	2018	ГБХЗХГ	БСУГ, НТБТ	Улсын төсөв Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш, сувилагч сэргээн засалчдыг сурган бэлтгэх, зориулалтын сурах бичиг, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг авна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018-2019	ГБХЗХГ	БСУГ, ЭМГ, ХХҮГ	Улсын төсөв Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэн олон улсын болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудын дэмжлэг арга зүйг авч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018	ГБХЗХГ	БСУГ, ЭМГ, ХХҮГ	Төсөл хөтөлбөр
		Хүнд нөхцөлд байгаа хүүхдийн гэр бүлд хандсан нийгмийн халамж, ажил үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ ХХҮГ	Төсөл хөтөлбөр
		Бүтэн өнчин хүүхдүүдэд хадгаламжийн хуримтлал бий болгох, их дээд сургуулиа төгсөөд аймаг орон нутагтаа ирж ажиллах	100%	2018-2021	ГБХЗХГ	АЗДТГ	Орон нутгийн төсөв

	хүсэлтэй бол ажлын байраар хангана.					
	Үрчлэгдсэн хүүхдэд тавих хараа хяналтыг нэмэгдүүлнэ.	100%	2018-2021	ГБХЗХГ	ХХҮГ	Төсөл хөтөлбөр
	Сургуулиуд дээр сэтгэл заслын өрөө байгуулах	5-аас доошгүй	2019-2020	БСУГ	ГБХЗХГ, ЭМГ	Улсын төсөв ОНХС Төсөл хөтөлбөр
	Хүүхэд хүүхдэдээ туслах хөдөлгөөнийг өрнүүлэн, хүнд нөхцөлд байгаа хүүхдэд туслах үйл ажиллагааг дэмжинэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ ЕБС	Орон нутгийн төсөв Төсөл хөтөлбөр
	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамгаалах "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийг хэвийн үйл ажиллагаатай болгоно.	100%	2018-2019	ГБХЗХГ	ЦГ, Нэгдсэн эмнэлэг	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Хүүхдийн аюулгүй, халдашгүй байдлыг хангах зорилгоор цэцэрлэг, сургууль, дотуур байр, хүүхдийн асрамж, халамжийн төв, хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчийн байр, мөрдөн байцаалтын өрөө, саатуулах болон цагдан хорих байр, хорих ангидкамерын хяналтын системийг нэвтрүүлнэ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018	ГБХЗХГ	АЗДТГ, БСУГ, Сумын ЗДТГ БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Цагдаагийн газарт хүүхэд байцаалт өгөх орчинг бүрдүүлэн тусгайлсан өрөөг бий болгоно.	1	2018	ЦГ	ГБХЗХГ	Төсөл хөтөлбөр
	Цагдаагийн кабоныг түшиглэн түр хамгаалах байрыг сумдад тохижуулна.	2-оос доошгүй	2018-2021	ГБХЗХГ ЦГ	Сумын ЗДТГ	Улсын төсөв ОНХС Төсөл хөтөлбөр
	Хүнд нөхцөлд амьдарч байгаа өсвөр насны хүүхдүүдийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулан амьдрах арга ухаан, хөдөлмөрийн дадал чадвар олгоно.	Үйл ажиллагаагаар	2018-2021	ГБХЗХГ	ХХҮГ, Сумын ЗДТГ, НТБТ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
	Хараа хяналтгүй хүүхдийг нийгэмшүүлэх амьдралд хөлөө олоход нь туслах нийгмийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.	50%	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ, НТБТ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр

		Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэл санааны болон эрүүл мэндийн нөхөн сэргээх ажил, үйлчилгээг чанартай хүргэнэ.	100%	2018-2021	ГБХЗХГ	ЭМГ, Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
3.5	Хүүхдийн хөгжил төлөвшлийн анхдагч орчин гэр бүл эцэг эхийн хандлагыг өөрчилж хүүхдээ хөгжүүлж төлөвшүүлэхэд тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлнэ.	Сайн эцэг эх сургалтын хөтөлбөрийг боловсруулан эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулж, гэр бүлийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх арга хэмжээг авах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018-2021	ГБХЗХГ	ЭМГ, Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Эерэг хүмүүжлийн аргаар эцэг эхчүүдэд зориулсан мэдээлэл сурталчилгааны материал боловсруулан түгээнэ.	100%	2018-2021	ГБХЗХГ	БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Гэр бүл хүүхэд хөгжлийн анхдагч орчин аймгийн эцэг эхийн зөвлөгөөнийг зохион байгуулна.	2 удаа	2018-2021	ГБХЗХГ	АЗДТГ БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Гэр бүлийн үнэт зүйл, өрх бүрийн бахархах зүйлийг бий болгох хөдөлгөөнийг өрнүүлж угийн /бичиг/ сантай болгоно.	20%	2018-2021	ГБХЗХГ НТБТ	БСУГ	Улсын төсөв ОНХС Төсөл хөтөлбөр
		Зорилтот өрхийн хүнсний аюулгүй байдал, чанарт анхаарах, хүнсний хомсдолд орохоос урьдчилан сэргийлж, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулна.	30%	2018-2021	ХХҮГ	АЗДТГ, ГБХЗХГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлсийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлнэ.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Зорилтод өрхийн гишүүдийг хөдөлмөр эрхлэх чадвар олгох сургалтад хамруулж ажлын байраар хангана.	30%	2018-2021	ХХҮГ	Аймгийн ЗДТГ, ГБХЗХГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Зорилтод өрхийн гишүүдэд гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зусланд түшиглэн зохион байгуулна.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	АЗДТГ, ГБХЗХГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр

		Гэр бүлд зөвлөгөө өгөх танхимын үйл ажиллагааг өргөжүүлэн стандартад нийцүүлж зөвлөн тусалж ажиллана.	100%	2018	ГБХЗХГ	БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
<b>Зорилт 4: Хүүхдэд ээлтэй засаглалыг бэхжүүлэн, хүүхдийн оролцоотойгоор орон нутгийн хүүхдэд чиглэсэн бодлого, шийдвэр, төсвийг нэмэгдүүлж, хяналт шинжилгээ үнэлгээний үр нөлөөг сайжруулна.</b>							
№	Зорилт	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсвийн эх үүсвэр
4.1	Хүүхэд хамгааллын тогтолцоог тэгш хамруулсан, тэгш боломжийг дэмжсэн тогтолцоо болгон хөгжүүлж, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлнэ.	Хамтарсан баг, хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	100%	2018-2021	ГБХЗХГ	БСУГ, аймаг, Сумын ЗДТГ	-
		Аймаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Хүүхдийн төлөө зөвлөлийн болон, хүүхдийн төлөө хийсэн ажлыг хэлэлцэж хэвшинэ.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	БСУГ, аймаг, Сумын ЗДТГ	-
		Хүүхдийн асуудал эрхэлсэн бүх шатны ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэн мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулна.	20-оос доошгүй	2018-2021	ГБХЗХГ	БСУГ, ЭМГ,	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн эрхийн улсын байцаагч хүүхдийн эрхийн зөрчилд хяналт тавих ажлыг зохион байгуулна.	100%	2018-2021	ГБХЗХГ	БСУГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Байгууллага бүр албан хаагчдынхаа гэртээ хараа хяналтгүй ганцаараа үлдэж байгаа бага ангийн хүүхдүүдийг эрсдлээс хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор сурч хөгжих орчинг нь дэмжсэн өрөөг бий болгоно.	10%	2018-2021	ГБХЗХГ	АЗДТГ, байгууллага уд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа болон хүүхдийг дэмжигч сайн дурын ажилтнуудыг дэмжин, урамшуулна.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	БСУГ, аймаг, сумын ЗДТГ, сургууль, цэцэрлэг	Улсын төсөв ОНХС Төсөл хөтөлбөр
		Хүүхдэд хууль зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг тогтмолжуулна.	100%	2018-2021	ГБХЗХГ	ХЗХ, ЦГ	-

		Хүүхдэд зүй бус хандах бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхэдтэй ажилладаг байгууллага бүрийг "Хүүхэд хамгааллын бодлого"-той болгоно.	60-аас доошгүй байгууллагад	2018-2021	ГБХЗХГ	БСУГ, сургууль, цэцэрлэг, байгууллагууд	-
		Хүүхдээ сонсох өдрийг бий болгож, тэдний дуу хоолой, санал хүсэлтийг сонсож шийдвэр гаргадаг болно.	Сум бүр	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ	-
		Хүүхэд бүрийг зөв төлөвшүүлэх, хүүхдэд ээлтэй бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийг бий болгож хүүхдэд ээлтэй байх нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч байгууллага иргэдийг хүүхдийн оролцоотойгоор шалгаруулж, урамшуулдаг болно.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	АЗДТГ, Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		"Байгууллагын эцэг эхийн зөвлөл" байгуулах, санаачлага өрнүүлж хэрэгжүүлнэ.	60-аас доошгүй	2018	ГБХЗХГ	АЗДТГ, Сумын ЗДТГ байгууллагууд	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
4.2	Хүүхдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн төлөвлөлт, төсөвлөлтийг хийж төсвийн тодорхой хувийг хүүхдийн төлөө үйл ажиллагаанд хувиарлана	ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж шийдвэр нь Хүүхдийн эрхийг дээдэлсэн байна.	100%	2018	ГБХЗХГ	ИТХ, АЗДТГ, Сумын ЗДТГ	-
		Сургууль, орон нутгийн түвшинд бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцад хүүхдийн оролцоог хангаж, тэдний санал, санаачилгыг дэмжин ажиллаж байгаа сайн туршлагыг дэлгэрүүлнэ.	Ажлын тоогоор	2018-2021	ГБХЗХГ	ИТХ, АЗДТГ Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Орон нутгийн хөгжлийн сангаас хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан төсөв, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж төсвийн 10 хувийг хүүхдэд зориулсан үйл ажиллагаанд зарцуулна.	Жил бүр 10%-аас доошгүй	2018	ГБХЗХГ	ИТХ, АЗДТГ Сумын ЗДТГ	Улсын төсөв ОНХС Төсөл хөтөлбөр
		Хүүхэд хамгааллын мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллийн сүлжээг сайжруулан, хүүхдэд тулгамдсан асуудлын талаар судалгаа хийж, дүгнэлт гаргана.	100%	2018-2021	ГБХЗХГ	Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр
		Хүүхдийн амьдрах орчинд нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлыг зохион	4 төрлөөр	2018-2019	ГБХЗХГ	Сумын ЗДТГ	Улсын төсөв Төсөл хөтөлбөр

		байгуулна. Дотуур байрны хүүхдийн амьдралын нөхцөл байдалд үнэлгээ хийнэ Үрчлэгдсэн хүүхдийн амьдралын нөхцөл байдалд үнэлгээ хийнэ. Хүүхдийн өдөр өнжүүлэх хувилбарт үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхэд, Сүм, хийдэд шавилан суусан хүүхэд гм					
4.3	Бизнес эрхэлж байгаа байгууллага нь хүүхдийн эрхийг хүндэтгэж бизнесийн бүхий л үйл ажиллагаа орчинд хүүхэд хамгаалал, аюулгүй байдлыг ханган хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамтын түншлэлийг хэрэгжүүлнэ.	Бизнесийн салбарынханы хүүхдийн эрх ба бизнесийн зарчмын тухай ойголт мэдлэгийг дээшлүүлэх сургалт арга хэмжээ зохион байгуулна.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	Аймгийн ЗДТГ	Төсөл хөтөлбөр
		Бизнесийн салбарын манлайлагч нартай хамтран ажиллаж хүүхдийн эрх ба бизнесийн зарчмыг түгээн дэлгэрүүлнэ.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	Аймгийн ЗДТГ	-
		Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018-2021	ГБХЗХГ	Аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ	Төсөл хөтөлбөр
		Жил бүр хүүхдэд ээлтэй бүтээгдэхүүнийг шалгаруулалтыг орон нутгийн үйлдвэрлэгчдийн дунд зохион байгуулна.	Жил бүр	2018-2021	ГБХЗХГ	Аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ	ОНХС Төсөл хөтөлбөр
		Хувийн хэвшлийн эх үүсвэрүүдийг тусламж хамгийн хэрэгтэй байгаа хүүхдүүдэд хүргэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2018-2021	ГБХЗХГ	Аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ	Төсөл хөтөлбөр



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 32

Есөнбулаг сум

Нөхөн үржихүйн эрүүл мэнд" дэд  
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "Ж" заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" дэд хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Нөхөн үржихүйн эрүүл мэнд" дэд хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусган батлуулж, биелэлтийн явц, үр дүнг жил бүрийн эцэст аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны  
04 дүгээр сарын 23-ны өдрийн 2018 дугаар  
тогтоолын 1-р хавсралт



## НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД ДЭД ХӨТӨЛБӨР

Говь-Алтай аймаг нь 56694 хүн амтайгаас 15494 нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, нийт хүн амын 27.3%-ийг эзэлж, 5 жилийн дундажаар 1295 эх эсэн мэнд амаржиж, 1298 хүүхэд эсэн мэнд бойжиж байна. Жирэмсний хяналтыг сайжруулах зорилгоор 2007 оноос “Гараас гарт нь жирэмсний давхар хяналт”-ын тогтолцоог нэвтрүүлж, жирэмсэн, төрөх эхчүүдийн эрүүл мэндийн байдалд давхар хяналт тавьж ажилласнаар жирэмсний эрт үеийн хяналтын хамралт 86,3 хувь, жирэмслэлтээс сэргийлэх аргын хэрэглээний түвшин 52.8%-д хүрч сүүлийн 5 жил дараалан эхийн эндэгдэлгүй ажиллалаа. Гэсэн ч жирэмсний хожуу үедээ хяналтанд орох тохиолдол дорвитой буурахгүй байгаа нь хотжилт, дэд бүтцийн хөгжил, оюутан сурагчид, түр оршин суугч, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байна.

Перинаталь эндэгдэл 2017 оны байдлаар 1000 амьд төрөлтөд 14.7 промилль байгаа нь улс аймгуудын дунджаас дээгүүр, эндэгдлийн шалтгаан нь амьгүй болон дутуу төрөлт, түүнд нөлөөлөх хүчин зүйл нь эхийн эрхтэн тогтолцооны эмгэг, хожуу хордлогын хүнд хэлбэр болж байна. Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 5 жилийн дундажаар 19.2 промилль /улсын 5 жилийн дундаж 15.1 промилль /улс, аймгийн дундажаас дээгүүр үзүүлэлтэй байна.

Нялхасын эндэгдлийн 90.9%-ийг эрт нярай үеийн эндэгдэл эзэлж, гол шалтгаан нь эхийн эрүүл мэнд, дутуу төрөлт, төрөлт тойронгийн эмгэг, гажиг хөгжил эзэлж, эмнэлгийн тусламж эрт хайх мэдлэг дутмаг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийн хангалтгүй зэрэг асуудлууд байна. Сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтээр тэмбүүгийн өвчлөл 166 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 2016 онд 24.0 , 2017 онд 47.3 болж, 23.3-аар нэмэгдсэн ба 5 жилийн үзүүлэлтээр 29.9 байгаа нь тэмбүүгийн халдвар улс, аймгийн 5 жилийн дунджаас дээгүүр үзүүлэлтэй байна. Улсын 5 жилийн дундаж 22.7, аймгийн 5 жилийн дундаж 20.8

2017 оны нийт бүртгэгдсэн өвчлөлийг нийгмийн байдлын зарим үзүүлэлтээр харуулахад : БЗДХ-аар өвчлөгсдийн 13.5%-ийг оюутан ,залуус, гэрлээгүй 46.6%, ажилгүй 31.9%-ийг, 14-19 насны өсвөр үе 12.4%, эрэгтэйчүүд 44.7% , эмэгтэйчүүд 55.2% нь байгаад анхаарч урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эдгээр зорилтод



бүлгийн хүн амд, ялангуяа эрэгтэйчүүдийн дунд байгаа БЗДХ-ыг илрүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна.

Жирэмсний хяналтанд 2017 онд орсон эмэгтэйчүүдийн 2.1%-д нь (улсын дундаж 2.4%) тэмбүү өвчин илэрсэн бөгөөд эрт илрүүлж, эрүүлжүүлснээр төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй ч төрөлхийн тэмбүү гарч болох эрсдэл байгааг анхааруулж байна. “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөрийг эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн дэлхий нийтийн бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг үндэслэн боловсрууллаа.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа**

### **2.1. Хөтөлбөрийн зорилго**

Эх, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулж, эрүүл мэндийн хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг ард иргэд хүргэх замаар эхийн сэргийлж болох эндэгдлийг гаргахгүй ажиллахад оршино.

### **2.2. Хөтөлбөрийн зорилт**

Зорилт 1. Эх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг иргэд хүргэнэ.

Зорилт 2. Нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээ, бүртгэл, мэдээлэл, хяналт үнэлгээг сайжруулна.

### **2.3 Хөтөлбөр хэрэгжих хугацаа**

Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

## **Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

### **3.1 Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

3.1.1 “Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг” болох хөдөлгөөн өрнүүлэн, эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулсан эрүүл мэндийн байгууллагад эдийн засгийн урамшуулал үзүүлэх

3.1.2. Эх, нөхөн үржихүйн эрүүл мэндэд орон нутгийн төсвөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх

3.1.3. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийн эрт илрүүлэг, зөвлөгөө, хяналт, оношилгоо, эмчилгээ, андрологи, үргүйдэл, цэвэршилтийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээг өргөжүүлэх

3.1.4. Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл мэдээллийг сайжруулж, жирэмсэн эмэгтэйг жирэмсний эхний 3 сарын хугацаанд илрүүлж, хяналтад тогтмол хамруулах

3.1.5. Малчид, отор нүүдэл хийж байгаа гэр бүлийн гишүүд, жирэмсэн эмэгтэйчүүдэд явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх;

3.1.6. Аймагт 50 ортой амаржих газрын барилгыг ашиглалтад оруулах;

3.1.7. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг жирэмсэн эхчүүд, эх барих, нярай, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад тогтмол хамруулах

3.1.8. Эх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хяналт үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвөлгөө үзүүлж, үр дүнг тооцож ажиллах

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

3.2.1. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл тухайлбал, бэлгэвч, дан болон хавсарсан дааврын эм, тариа, ерөндөг, суулгац, яаралтай ууж жирэмслэхээс сэргийлэх эм зэргээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг хангах;

3.2.2. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сан бий болгох

3.3.3. Эх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, мэдлэг олгох ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

### **Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт**

4.1. Хөтөлбөрийн нийгэмд үзүүлэх үр нөлөө:

4.1.1 Гэр бүл төлөвлөлтийн хангагдсан хэрэгцээ нэмэгдэж, хүсээгүй жирэмслэлт болон үр хөндөлт буурна.

4.1.2. Эх, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах орчин, хүртээмж, чанар сайжирна.

4.1.3. Ургийн болон нярайн төрөлхийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэн хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлнэ.

4.1.4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд төрийн болон төрийн бус байгууллага, хамт олон, иргэний оролцоо нэмэгдэж, эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

4.2. Хөтөлбөрийн эдийн засгийн үр нөлөө

4.2.1. Эх, хүүхдийн эндэгдлээс урьдчилан сэргийлэх хамгийн үр ашигтай, нотолгоонд суурилсан арга болох нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж,

үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэснээр хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлнэ.

4.2.2. Гэр бүл төлөвлөлт нь эрүүл мэндийн зардлыг бууруулахаас гадна эмэгтэйчүүдийн эрхийг дэмжиж, тэдний боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх замаар гэр бүлийн сайн сайхан байдлыг дэмждэг.

4.2.3. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэн пренатал оношилгоо эмчилгээ, үргүйдэл, зэрэг зарим тусламжийг орон нутагтаа үзүүлснээр иргэнд учрах эдийн засгийн дарамт буурна.

4.2.4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулснаар жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэл буурч, эхийн эндэгдлээс сэргийлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал буурна.

4.2.5. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг үзүүлснээр бага өртгөөр олон нярайн амь насыг аварна.

4.2.6. Хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэлтийг сайжруулснаар халдварт бус өвчний шалтгаант нас баралтыг бууруулна.

#### Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Улсын эрүүл мэндийн үзүүлэлт		Говь-Алтай аймгийн эрүүл мэндийн үзүүлэлт		
	Суурь үзүүлэлт		Хүрэх түвшин		
	2016	2017	2018	2019	2020
<b>Үр нөлөөний шалгуур үзүүлэлт</b>					
Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд)	26.9	0	0	0	0
Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	16.8	16.4	16	15	13
Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	9.2	9.3	8.9	8.7	8.5
Перинатал эндэгдлийн түвшин (1000 нийт төрөлтөд)	12.9	14.7	14	13	11.9
<b>Үр дүнгийн шалгуур үзүүлэлт</b>					
Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	84.7	86.8	87.0	88.0	89.0
Жирэмсний хугацаанд 6 болон түүнээс дээш үзүүлсэн хувь	77.5	85.5	86.0	87.0	88.0
Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын түвшин /100,000 амьд төрөлтөд/	53.7	0	0	0	0

Жирэмсний 18-21 долоо хоногийн хугацаанд ургийг (бүтцийн) хэт авиан шинжилгээнд хамруулсан хувь	50	10	25	40	50
Төрөлт бүрт нэг удаагийн цомог хэрэглэсэн хувь	30	90	95	98	100
Кесарево хагалгааны дараах ноцтой хүндрэлийн хувь	24.8	0	0	0	0
Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хэрэгжилтийн хувь	70	80	85	90	100
Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж байгаа нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь	48.2	50.2	52.0	53.0	54.0
Үр хөндөлтийн түвшин /1000 амьд төрөлтөд/	224.6	34.3	34.2	34.1	34.0

### **Тав. Хөтөлбөрийн санхүүжилт**

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. Улсын төсөв;

5.1.2. Орон нутгийн төсөв

5.1.3. Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө;

5.1.4. Олон улсын байгууллага, гадаад улс орны төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, хөнгөлөлттэй зээл, тусламж;

5.1.5. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

5.1.6. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

### **Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан хяналт-шинжилгээ, үнэлгээ**

6.1 Эрүүл мэндийн газар улирал бүр хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийнэ

6.2. Нэгжүүдийн хэрэгжилтийн тайланг Эрүүл мэндийн газарт нэгтгэн хагас, бүтэн жилээр АЗДТГ-ын НБХ-т тайлагнана.

6.3. Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ИТХТ-д тайлагнана.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны  
04 дүгээр сарын 25-ны өдрийн 42 дугаар  
тогтоолын 4-р хавсралт



НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа			Санхүүжилт /сая төг/
						2018	2019	2020	
Зорилт 1. Эх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг иргэд хүргэнэ.									
1	“Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг” болох хөдөлгөөн өрнүүлэн, эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулсан эрүүл мэндийн байгууллагад эдийн засгийн урамшуулал үзүүлэх	Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг”, шалгаруулах болзол боловсруулна.	Шалгарсан байгууллагын тоо	ЭМГ	АЗДТГ НЭ СЭМТ ӨЭМТ	+	+		5.0 ОНТ
2	Эх, нөхөн үржихүйн эрүүл мэндэд орон нутгийн төсвөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх	Аймаг, сумд төрж байгаа эхчүүдийн төрөлтийн нэг удаагийн иж бүрдлийг орон нутгийн төсвөөс хангах арга хэмжээ	Хангагдсан төрөлтийн нэг удаагийн иж бүрдлийн тоо	ЭМГ	АЗДТГ НЭ СЭМТ	+	+	+	92.0 Улсын төсөв
3	Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл мэдээллийг сайжруулж, жирэмсэн эмэгтэйг жирэмсний эхний 3 сарын	Өрх, сумын нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, жирэмсэн	нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, жирэмсэн эмэгтэйчүүдийн	ЭМГ	НЭ СЭМТ ӨЭМТ	+	+	+	

	хугацаанд илрүүлж, хяналтад тогтмол хамруулна.	эмэгтэйчүүдийн жил бүр судалгаа	бүртгэл мэдээлэл						
4	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрхтэн тогтолцооны эмгэгийн эрт илрүүлэг, зөвөлгөө, хяналт, андрологи, үргүйдэл, цэвэршилтийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээг байгуулна.	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээ байгуулагдана.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанар сайжирна.	ЭМГ	АЗДТГ НЭ	+	+		5.0 ОНТ
5	Аймагт 50 ортой амаржих газрын барилгыг ашиглалтад оруулна.	Ашиглалтад оруулсан байна.	Эх,нярайн тусламж үйлчилгээний хүртээмж сайжирна.	ЗДТГ	ЭМГ НЭ	+			5200.0 Улсын төсөв
6	Малчид, отор нүүдэл хийж байгаа гэр бүлийн гишүүд, жирэмсэн эмэгтэйчүүдэд явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ	Явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулна.	Эмэгтэйчүүдийг хамруулсан хувь, эрүүлжүүлсэн тоо	ЭМГ	АЗДТГ НЭ СЗДТГ СЭМТ ӨЭМТ	+	+		16.0 ОНТ
7	Жирэмсэн эхчүүд, эх барих, нярай, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулна.	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургалт хийгдсэн байна.	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн чадавхжуулна Сургалтын тоо эмч мэргэжилтний тоо	ЭМГ	АЗДТГ НЭ	+	+		2.0 Улсын төсөв
8	Эх,нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хяналт	Эх,нөхөн үржихүйн эрүүл мэндийн	Эрх бүхий албан тушаалтны тушаал,	ЭМГ	АЗДТГ НЭ СЗДТГ	+	+		4.0 Улсын төсөв

	үнэлгээ хийж мэргэжил арга зүйн зөвөлгөө үзүүлж, үр дүнг тооцож ажиллах	тусламж, үйлчилгээний дэмжлэгт хяналт	шийдвэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ		СЭМТ ӨЭМТ				
Зорилт 2. Нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээ, бүртгэл, мэдээлэл, хяналт үнэлгээг сайжруулна.									
1	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангана.	ЖСЭХ-ийн захиалга, түгээлтийн хуваарь	Эрүүл мэндийн газрын даргын тушаал	ЭМГ	СЭМТ ӨЭМТ	+	+		40.0 Улсын төсөв
2	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан бий болно	Мэдээллийн нэгдсэн сан байгуулагдсан байна.	Мэдээллийн нэгдсэн сан	ЭМГ	АЗДТГ НЭ СЭМТ ӨЭМТ	+	+		1.0 Улсын төсөв
3	Эх, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, мэдлэг олгох ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	НҮЭМ-ийн мэдээлэл, зөвөлгөө өгөх сайн дурын ажилтнуудыг бэлтгэх	Бэлтгэгдсэн сайн дурын тоо	ЭМГ	НЭ, СЭМТ ӨЭМТ, ТББ	+	+		6.0 Төсөл, Хөтөл бөр
Нийт:				5377 сая төгрөг					
Улсын төсөв:				5345 сая төгрөг					
Орон нутгийн төсөв:				26 сая төгрөг					
Төсөл, хөтөлбөр:				6 сая төгрөг					